

Монгол Улс ОХУ-ын стратегийн түншлэлийн хэрэгжилт

А.Даваасүрэн¹

***Abstract:** The theory of the strategic partnership of which it is implemented international practices, strategic partnerships and bilateral cooperation and strategic partnership agreements difference, Mongolian, Russian and Chinese strategic partnership agreement between the causes and interests of the parties, the importance of this agreement, the three countries made an agreement with each other through comparative studies define the characteristics of each contract out, their implementation and analysis.*

* * *

Стратеги (strategy) Өөрт байгаа нөөц, бололцоог үр ашигтай үр дүнтэй бүрэн ашиглаж асуудлыг шийдвэрлэх, сонгож авсан зорилгыг хэрэгжүүлэх, амжилтанд хүрэх арга буюу төлөвлөгөө болно². Стратеги нь дэлхий ертөнц дээр хувьсамтгай, тодорхойгүй нөхцөл байдал үүсэж болзошгүй бөгөөд урьдчилан таах боломжгүй эрсдэлийн үед аливаа улс, гүрнүүдийн оршин тогтнох, тэсэж үлдэхэд хэрэглэдэг хамгийн нарийн хүчирхэг зэвсэг гэж үздэг. Энэхүү асуудлыг судалж байгаа шинжлэх ухааны төрлийг стратегийн удирдлага гэж нэрлэх тал байдаг. Тэгвэл стратегийн удирдлага нь байгууллагын ирээдүйд тодорхойлсон үүрэг, зорилгыг биелүүлэхэд чиглэсэн боломжит нөөцийг бүрэн дүүрэн, үр дүнтэй ашиглах шийдлийг боловсруулах, хэрэгжүүлэх урт хугацаанд хөгжлөө удирдах, хянах урлаг мөн³. Иймээс стратеги нь улс

1. ШУА-ийн Олон Улсын Харилцааны Хүрээлэнгийн ЭШТА, доктор (Sc.D), профессор
davaasuren13@yahoo.com

2. <http://www.businessdictionary.com/definition/strategy.html>

3. Томпсон А.А., Стрикленд А. Дж.«Стратегический менеджмент» Искусство разработки и реализации стратегии: Учебник / Пер с англ под ред Л.Г Зайцева, М.Соколовой - Банки и биржи, ЮНИТИ, 1988, - 576с

төр, эдийн засгийн, нийгмийн, үйлдвэрлэлийн, экологийн, шинжлэх ухаан, техникийн, удирдлага, зохион байгуулалтын гэх мэт хоорондоо уялдаа бүхий янз бүрийн зорилго, зорилтуудын үндэслэлийг боловсруулах арга хэрэгсэл гэж үзэж болно. Энгийн үгээр хэлбэл стратеги нь урт хугацаанд томоохон өөрчлөлт шинэчлэлт хийхийн тулд нийгэм, эдийн засгийн, экологийн, инноваци-хөрөнгө оруулалтын бодлогыг төлөвлөж хэрэгжүүлэхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл стратеги нь урт хугацаанд эрс шинэчлэлт хийхийн тулд өнөөдөр үйл ажиллагаагаа идэвхитэй эхлүүлэхийг шаардсан ирээдүйгээ баримжаалсан бичиг баримт гэж болно⁴.

Иймд стратеги нь аливаа байгууллага, аж ахуйн нэгж нь алс хэтийн томоохон цаг хугацааны өөрчлөлт, шинэчлэлтийг хийхэд нөлөөлж болохуйц гадаад дотоод хүчин зүйлсийг тооцсоны үндсэн дээр бодит нөөц бололцоогоо хамгийн зохистой бүрэн ашиглаж зорилгодоо хүрэх удирдлага, зохион байгуулалтын болон үйл ажиллагааны төлөвлөгөө гэж үзэж болохоор байна.

Дэлхийн улс орнуудын геополитик болон гадаад бодлогын судалгаандаа «хөгжлийн стратеги», «хамтын ажиллагааны стратеги», «стратегийн түншлэл» гэсэн ойлголтуудыг ихээхэн ашиглаж байна. Стратегийн түншлэл нь (strategic partnership), (стратегическое партнерство), дараах дотоод гадаад гэсэн хэлбэрүүдтэй байдаг. Үүнд:

1. Дотоод (domestic) түншлэл

- Төр болон хувийн хэвшлийн (Public and private partnership);
- Хувийн хэвшлийн бизнесийн байгууллагын хоорондын (private partnership).

Стратегийн түншлэлийн хамгийн энгийн хэлбэр нь үйлдвэрлэгч, түгээгч, борлуулагч нарын хамтын ажиллагааны алс хэтийн зорилт юм. Хоёр ба түүнээс дээш компаниуд бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт (бөөний) борлуулалт (жижиглэн), зар сурталчилгаа, маркетинг гэх мэт сүлжээнд хамтарч оролцох аж ахуйн харилцааг хэлж болно. Жишээ нь, автомашин үйлдвэрлэгч компани нь өөрийн

4. Стратегический менеджмент. Основы стратегического управления /М.А. Чернышев [и др.]. – Ростов н/Д: Феникс, 2009. - 506, [1] с.- (Высшее образование). С-11

үйлдвэрлэлд шаардлагатай эд анги нийлүүлэгч өөр компанитай, эсвэл автомашины хөгжим борлуулагч компанитай стратегийн түншлэлийн гэрээгээр хамтран ажиллаж байна. Иймд стратегийн дотоод түншлэл гэж хоёр аж ахуйн нэгжүүд урт хугацаанд тавьсан зорилгодоо хүрэхийн тулд бие биеийнхээ дутууг нөхөж, давуу талуудаа ашиглан өөрсдийн үйл ажиллагааг илүү хялбар болгож нийт зардлаа багасгах замаар хамтран ажиллаж байгуулж буй гэрээ гэж үзэж болно. Стратегийн түншлэлийн гэрээг байгуулах нь олон давуу талтай байдаг. Жишээ нь өөр өөр салбарт үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд дунд болон урт хугацаанд гэрээ байгуулж хамтын хүчээр мэдлэг, ур чадвар, нөөц бололцоо, чадамжаа ашиглан томоохон зорилгод хүрч байна. Роберт М. Грант «Орчин үеийн стратегийн шинжилгээ» номондоо «компаниуд стратегийн түншлэлд орсоноор хамтрагч компанийхаа давуу талыг ашиглах замаар нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах зардлаа хэмнэж, аль аль нь урт хугацаанд эдийн засгийн ихээхэн ашиг олох⁵» явдал гэж дурьдсан байна.

2. Гадаад (foreign) түншлэл

- Улс орнуудын төр засгийн газрын байгууллагуудын хооронд (Public partnership);
- Гадаад улсын төр, засгийн газрын байгууллага, хувийн хэвшлийн бизнесийн байгууллагын хоорондын (Public and private partnership);
- Гадаад буюу олон улсын (International strategic partnership) гэх мэт.

Тэгвэл дээрхи түншлэлийг гадаад «олон улсын стратегийн түншлэл» гэж нэрлэх ба энэ нь түншүүд бие биентэйгээ гэрээ байгуулах замаар геоулс төр, эдийн засаг, бизнесийн зорилготой нэгдэж хамтын ажиллагааны бүх хэлбэрийг өөртөө багтаасан онцгой харилцаа болж байна. Тухайлбал, 2013 оны 11 дүгээр сард ОХУ-ын төрийн өмчийн «Росатом» компанитай Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Эрчим хүчний яамтай байгуулсан стратегийн түншлэлийн гэрээний хүрээнд 2030 он гэхэд тус улсад атомын цахилгаан станц шинэ барьж цөмийн эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээг 5-25 хувиар нэмэгдүүлэх төлөвлөгөөг тусгасан байна⁶.

5. <http://www.businessdictionary.com/definition/strategic-partner>

6. <http://azerros.ru/news/20254-ctrategicheskoe-partnerstvo>

Гадаад стратегийн түншлэлийн өөр нэг жишээ бол Энэтхэг, Японы хооронд 2008 оны 10 сард байгуулсан стратегийн түншлэлийн гэрээ юм. Ази-Номхон Далайн бүс нутагт үүсэж буй улс төрийн тогтворгүй, төвөгтэй байдал, БНХАУ-ын өсөн нэмэгдэж байгаа эдийн засаг, цэрэг, зэвсэгийн хүч, нөлөө, Хойд Солонгосын цөмийн баллистик пуужингийн туршилт, Энэтхэгтэй хилийн зөрчилтэй байдаг Пакистан улсын цөмийн технологийн худалдаа зэрэг геополитикийн асуудалууд нь энэхүү гэрээг байгуулах үндэслэл болсон гэж олон улсын шинжээчид үзэж байна. Энэтхэг Япон энэхүү гэрээг байгуулсан нь хоёр улсын аюулгүй байдал, батлан хамгаалах, цэргийн техникийн салбарт хамтран ажиллах, хамтарсан цэргийн хээрийн сургууль хийх, эргийн хамгаалалтын албадуудын хооронд нягт хамтын ажиллагаа сайжиргах, батлан хамгаалахын сайд нарын уулзалт тогтмолжих ач холбогдолтой болж Японы хувьд Энэтхэг улс нь стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан 3 дахь улс болсон гэж үздэг⁷.

Египетийн Ерөнхийлөгч Абдель Фаттах аль-Сиси, БНХАУ-ын дарга Си Зиньпин нар Бээжин хотод Хятад, Египет улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 58 жилийн ойг тохиолдуулан стратегийн иж бүрэн түншлэл гэрээнд гарын үсэг зурсан байна. Энэхүү стратегийн түншлэлийн гэрээний хүрээнд хоёр улс дэд бүтэц, төмөр зам, сэргээгдэх эрчим хүч, соёлын хамтын ажиллагааг сайжруулах, Египетийн эдийн засгийг сэргээхэд туслах, Суэцийн сувгийг өргөжүүлэх төсөлд хятадын хөрөнгө оруулагчдад ашигтай нөхцлийг бүрдүүлэхээр болсон⁸.

Энэтхэг улс сүүлийн 10 гаруй жилд ямар нэгэн эвсэл холбоонд нэгдэхээс зайлсхийх замаар «стратегийн түншлэлийн гэрээг АНУ, ОХУ, БНХАУ, Япон, Индонез, Австрали, Вьетнам, Өмнөд Солонгос, Иран, АСЕАН-ы орнууд, Афганистан зэрэг улсуудтай байгуулсан байна. Тухайлбал, Энэтхэг ОХУ-ын хооронд байгуулсан стратегийн түншлэл нь цэрэг, техникийн салбарт хамгийн эрчимтэй хөгжүүлэх ОХУ-аас Энэтхэг Улс цэргийн тээврийн болон сөнөөгч нисэх онгоц, усан онгоцноос эсрэгүүцэгч «БраМос» пуужингийн төхөөрөмж болон бусад цэргийн зориулалттай зэвсэг техник, технологийг худалдан авах, оросын мэргэжилтнүүд энэтхэгийн цэргийнхнийг зааж сургахад чухал хөшүүрэг болж байна.

7. <http://ru.journal-neo.org/2013/08/26/rus-strategicheskoe-partnerstvo>

8. english.cn

Дээрх гэрээнүүдэд дүгнэлт хийхэд ОХУ, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улстай байгуулсан стратегийн түншлэлийн гэрээ нь ОХУ-ын хувьд өөрийн геополитик, эдийн засгийн нөлөөг Африк тивийн өмнөд хэсэгт бэхжүүлэх, Японы хувьд БНХАУ-ын өсөн нэмэгдэж байгаа геоулс төр, эдийн засгийн хүчийг саармагжуулах, хятадын талаас газар нутгийн маргаантай асуудлыг цэргийн хүчээр шийдвэрлэж болзошгүй аюулаас сэргийлэх, харин БНХАУ-ын хувьд Ойрхи Дорнод, Арабын ертөнцөд өөрийн нөлөөг бий болгох зорилго агуулж байна. Энэтхэг Улсын хувьд аль нэг эвсэлд үл нэгдэх зарчмаар дэлхийн нөлөө бүхий том улсуудтай «стратегийн түншлэл»-ийн гэрээг байгуулах замаар өөрийн аюулгүй байдал, үндэсний эрх ашгаа олон улсын түвшинд хамгаалах стратегийн бодлого агуулагдаж байна.

Дэлхийн улс орнуудын хоорондын хамтын ажиллагааг зэрэглэлээр нь авч үзвэл:

- Хоёр талын хамтын ажиллагаа
- Стратегийн түншлэл
- Эдийн засгийн эвсэл буюу холбоо (гааль болон худалдааны холбоо)
- Улс төрийн болон цэргийн эвсэл буюу холбоо гэх мэт.

Хоёр талын хамтын ажиллагаа нь дэлхийн улс орнууд энх тайванчаар зэрэгцэн орших, бие биенийхээ тусгаар тогтнол, үндэсний эрх ашгийг харилцан хүндэтгэж эдийн засаг, үйлдвэрлэл, технологи, шинжлэх ухаан, боловсрол, соёл, урлагийн салбар дахь хамтын ажиллагааг багтаасан эдийн засаг, нийгэм, хүмүүнлэгийн шинж чанарыг агуулж байна.

Хоёр талт хамтын ажиллагаанаас стратегийн түншлэлийн ялгагдах онцлог нь улс орнууд дэлхий дээр болон бүс нутагт байр суурь, нөлөөгөө бий болгох, батлан хамгаалах салбараа бэхжүүлэх, атом, цөмийн салбарт хамтран ажиллах, геополитик, цэрэг, зэвсэгийн салбарт хамтран ажиллаж стратегийн зорилготой байгуулж байна. Гэхдээ стратегийн түншлэл нь хоёр орны хоёулангынх нь эрх ашигт нийцсэн, стратегийн зорилго агуулсан урт хугацаатай хийгдэж байна. Зарим улсуудын хувьд тунхаглалын шинж чанартай байдаг. Улс орнуудын хоёр талт хамтын ажиллагаа хамгийн дээд шатандаа

хүрсэнээр стратегийн түншлэлийн гэрээ болон хувирч цэрэг, зэвсэг, улс төрийн шинж чанартай болж байна. Улс орнууд стратегийн түншлэлийн гэрээ нь ямар нэгэн эвсэл, холбоонд нэгдэхийн өмнөх үе шат гэж ч зарим судлаачид үздэг.


1. БНХАУ, ОХУ-ын хоорондын стратегийн түншлэлийн гэрээг авч үзье:



Манай хоёр хөршийн хооронд 2001 оны 7 сарын 16 нд байгуулсан стратегийн түншлэлийн гэрээнд анх удаа энхтайванаар зэрэгцэн орших, олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй мөрдөх, дэлхийн хамтын нийгэмлэгийн бүх гишүүний хууль ёсны эрх ашиг, үндэсний бүрэн эрхийг хүндэтгэх зэрэг зарчмуудыг тодорхойлж өгсөн байдаг. Энэхүү гэрээ нь хоёр талын улс төр, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа эрчимжихэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. Энэхүү гэрээг байгуулахад хоёр улсын төрийн тэргүүнүүдийн хувийн найрсаг дотно харилцаа, олон улсын болон хоёр улсын асуудлаар тогтмол санал солилцох байдал, олон улсын асуудлаар нэгдмэл нэг байр суурь чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. Сүүлийн жилүүдэд ОХУ, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэл нь урьд өмнө байгаагүй ач холбогдолтой болж байна. Энэ нь Ази-Номхон Далайн бүс нутагт байрлах дэлхийн хамгийн том гүрнүүд бөгөөд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүд, цөмийн зэвсэгтэй гүрнүүдийн хувьд ОХУ, БНХАУ хүн төрлөхтний өмнө тулгамдаж буй асуудлаар хоорондоо зөвшилцөх шаардлага тулгарч байдагтай холбоотой юм. Тухайлбал, Арабын ертөнц, Төв Ази, Ази-Номхон Далайн бүс нутаг, Солонгосын хойгийн байдал, Украины хямрал, АНУ болон ЕХ-ны зүгээс ОХУ-ын эсрэг авч буй эдийн засгийн хориг арга хэмжээний үр дүн зэрэг нь ОХУ, БНХАУ-ын удирдагчдийг гадаад бодлого, уламжлалт харилцаагаа эргэж харахад хүргэж стратегийн түншлэлээ гүнзгийрүүлэх замаар АНУ тэргүүтэй барууны орнуудын эсрэг хамтын хүчээр зогсоход хүргэж байна.

Монгол Улс, ОХУ-ын хооронд байгуулсан стратегийн түншлэлийн гэрээг авч үзэхэд 1990 оноос өмнө хоёр орны хооронд олон жилийн ах дүүгийн бүх талын найрсаг хамтын ажиллагаатай байж ирсэн уламжлалтай бөгөөд тухайн үед Монгол улсын социализмын бүтээн байгуулалтад ялангуяа нийгмийн амьдралын бүх салбарт (боловсрол, эрүүл мэнд, хөдөө, аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтцийн хөгжил, соёл, шинжлэх ухаан гэх мэт) үсрэнгүй өсөлт хөгжилтийг бий болгоход ЗХУ-ын эдийн засаг, санхүү, техникийн тусламж дэмжлэг үнэлж барашгүй хувь нэмэр оруулсан. Энэхүү тусламж дэмжлэг нь Монгол Улсыг ХХ зууны өмнөх дэлхийн туйлын ядуу хоцрогдсон улсыг түүхийн маш богино хугацаанд дэлхийн хөгжиж буй орны хэмжээнд хүргэхэд маш чухал үүрэг гүйцэтгэсэнийг цохон тэмдэглэх хэрэгтэй. Тухайн үеийн дэлхийн хүйтэн дайн, хоёр системийн зөрчил, үзэл сурталын тэмцэл нь Монгол Зөвлөлтийн хооронд бүх талын ах дүүсэг нягт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх чухал суурь болсон гэж үзэх талтай.

Тэгвэл 1990 онд хуучин социалист систем, болон ЗХУ задарснаар дэлхийн улс гүрнүүд тоглоомын нэг дүрмээр тоглох болсон нь Монгол Улс, ОХУ хоорондын уламжлалт харилцаанд зарчмын өөрчлөлтийг оруулж энэ нь манай хоёр улсын хоорондын худалдааны эргэлт буурах шалтгаан болсон.



2000 онд Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтэд ОХУ 21,8 хувийг эзлэж байсан бол 2013 онд 15,3 хувийг эзлэж байна. Манай улсаас ОХУ руу мах махан бүтээгдэхүүн, хайлуур жонш гэсэн 2 төрлийн бараа, бүтээгдэхүүн гарч байна. Ийнхүү хоёр улсын хооронд хийж буй худалдааны эргэлт огцом буурахад нөлөөлсөн олон хүчин зүйлийг дурьдаж болно. Тэдгээрээс хамгийн гол нь дэлхийн хүйтэн дайны төгсгөл, үзэл суртал, цэрэг дайны сөргөлдөөн тэмцэл дуусантай холбон тайлбарлаж болно.

Гэвч ОХУ-ын төр, засгийн тэргүүнүүд хоёр талын хамтын ажиллагааг шинэ нөхцөлд сэргээхэд ихээхэн ач холбогдол өгч иржээ. Тухайлбал, хамгийн сүүлд Ерөнхийлөгч Д.А.Медведев 2009 оны 8 дугаар сарын 25-26-нд Монгол Улсад хийсэн төрийн айлчлалынхаа үеэр хоёр талын хамтын ажиллагааг гүнгийрүүлэх зорилгоор 4 хэлэлцээрт гарын үсэг зурж «стратегийн түншлэлийн гэрээг» байгуулж байсан бол 2014 оны 9 сарын 3-нд Ерөнхийлөгч В.В.Путины Монгол Улсад хийсэн ажлын айлчлалын үеэр хоёр тал 2009 онд байгуулсан ОХУ, Монгол Улс хоорондын стратегийн түншлэлийг улам гүнзгийрүүлэн бэхжүүлэх зорилгоор 15 хэлэлцээрт гарын үсэг зурж Монголын ашигт малтмалын ордуудыг хамтран ашиглах, дэд бүтэц, төмөр замын салбарт ажиллах, хоёр улсын худалдаанд учирч буй саад бэрхшээлийг хөнгөвчлөх, хоёр улсын иргэд харилцан визгүй зорчих асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн байна.



Хоёр улсын хооронд «стратегийн түншлэлийн гэрээг» байгуулах ашиг сонирхолыг авч үзье. ОХУ-ын хувьд манай улстай байгуулсан гэрээ нь нэгдүгээрт, Сибирь, Алс Дорнодын бүс нутгийнхаа аюулгүй байдлыг хангах, хоёрдугаарт, Ази Номхон Далайн бүс нутагт өөрийн стратегийн нөлөөг бэхжүүлэх, гуравдугаарт, БНХАУ-тай харилцах харилцаанд Монгол Улсыг хөшүүрэг болгон ашиглах, дөрөвдүгээрт, дэлхий дахинд хомсдож буй эрчим хүчний нөөцөд хяналт тавих,

түүнийг хуваарилалтад өөрийн нөлөөг бий болгох, тавдугаарт, Монгол дахь оросын талын хөрөнгийг хамгаалах гэх мэт.

Тэгвэл Монгол Улсын хувьд ОХУ-тай байгуулсан стратегийн түншлэлийн ашиг сонирхол нь *нэгдүгээрт*, өөрийн үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолоо хамгаалах, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг бэхжүүлэх, *хоёрдугаарт*, 1990 өмнө байсан уламжлалт бүх талын харилцаагаа сэргээх, *гуравдугаарт*, ОХУ-аас авдаг нефтийн бүтээгдэхүүний хэрэгцээгээ хангах, *дөрөвдүгээрт*, Ази Номхон Далайн бүс нутагт өөрийн орон зайг бий болгох, *тавдугаарт*, ОХУ-ын хөрөнгө оруулалтыг өөрийн эдийн засаг руугаа оруулах гэх мэт. Дээрхи ашиг сонирхол, нөхцлүүдийг тооцож үзэхэд стратегийн түншлэлийн гэрээг байгуулах асуудал дээр хоёр улсын эрх ашиг давхцаж байна гэж үзэх үндэстэй байна.

Монгол Улс, ОХУ-ын хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн бодит байдлаас харахад 2009 онд ОХУ-ын Ерөнхийлөгч Д.А.Медведевийн байгуулсан, 2014 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины ажлын айлчлалаар баталгаажуулсан нь стратегийн түншлэлийн гэрээ нь цэвэр геополитик, тунхаглалын буюу билэгдэлийн шинж чанартай гэрээ болжээ гэж үзэхээр байна. Энэ ч утгаараа ОХУ-ын Ерөнхийлөгчдын Монгол Улсад хийсэн дээрх 2 айлчлал нь Халхын голын дайны 70 болон 75 жилийн ойг тэмдэглэх үетэй давхцаж байна. Харин ОХУ-ын Ерөнхийлөгчийн сүүлчийн айлчлалаар хоёр улсын иргэд визгүй зорчих асуудлыг шийдсэн хоёр орны худалдааны болон эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд томоохон түлхэц болно гэж найдаж байна.

2. Монгол Улс, БНХАУ-ын хооронд байгуулсан стратегийн түншлэлийг авч үзье. 1990 оноос хойшхи хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа маш богино хугацаанд маш эрчимтэй хөгжиж, 2000 онд манай улсын гадаад худалдааны нийт эргэлтэд БНХАУ 34,8 хувийг эзлэж байсан бол 2013 онд 52 хувийг эзлэх болжээ. (Зураг1-ээс харна уу.) Ийнхүү хоёр улсын хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны эрчимтэй хөгжил нь 2011 онд Монгол Улс, БНХАУ-ын стратегийн түншлэлийн гэрээг байгуулах

үндэс болжээ гэж дүгнэхэд хүрч байна⁹. Энэхүү гэрээг 2014 оны 8 сард БНХАУ-ын дарга Си Зиньпин манай улсад айлчлах үеэр улам баталгаажуулсан байна.



Уг гэрээг байгуулсан хоёр улсын ашиг сонирхолыг зэрэгцүүлэн дүгнэж үзвэл: БНХАУ-ын хувьд *нэгдүгээрт*, Ази Номхон далайн бүс нутагт өөрийн стратегийн байр суурь, нөлөөг бэхжүүлэх, *хоёрдугаарт*, Монгол Улсад өөрийн бүх талын нөлөөг (улс төр, эдийн засаг, хөрөнгө санхүү, дэд бүтэц, эрчим хүч, байгалийн баялаг, аж үйлдвэр,) нэмэгдүүлэх замаар ОХУ-ын эрх ашиг, нөлөөг устгах, *гуравдугаарт*, Монгол Улс дахь гуравдагч хөршийн байр суурь, нөлөөг устгах, *дөрөвдүгээрт*, Монгол Улстай цэрэг зэвсгийн салбарт хамтын ажиллагааг эрчимжүүлэх замаар хяналтаа тогтоох гэх мэт.

Монгол Улсын хувьд нэгдүгээрт, дотоодын зах зээл дээрх бараа бүтээгдэхүүний хомсдолыг арилгах, хоёрдугаарт, хятадын үйлдвэрийн тоног төхөөрөмж, хямд ажиллах хүчийг ашиглах, гуравдугаарт, хятадын хөрөнгө оруулалтыг өөрийн эдийн засаг руу оруулах эрх ашгийг агуулж байна.

Энэтхэг мэтийн улсын стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан практик ач хоблогдолтой харьцуулахад Монгол-Хятадын стратегийн түншлэлийн гэрээ нь манай улсын хувьд цэвэр эдийн засгийн ашиг сонирхолыг агуулж байхад БНХАУ-ын хувьд цэвэр геополитикийн ашиг сонирхолыг агуулж байна гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

Эцэст нь хэлэхэд хоёр хөрштэйгээ байгуулсан Монгол Улсын стратегийн түншлэлийн гэрээг цаг хугацаа, ач холбогдол, ашиг сонирхолын хувьд шинжлэж үзэхэд ОХУ, БНХАУ Монгол Улсад өөрсдийн байр суурь, нөлөөг хадгалах, бэхжүүлэх улмаар бие биенээ шахах тал дээр далдуур хоорондоо өрсөлдөж ялангуяа БНХАУ манай улс дахь ОХУ-ын нөлөөг багасгах талаар маш их

9. <http://www.mongolianminingjournal.com/>

хүчин чармайлт тавьж буй дүр зураг ажиглагдаж байна. Жишээ нь стратегийн түншлэлийн гэрээг анх Монгол Улстай 2009 онд ОХУ, 2011 онд БНХАУ тус тус байгуулсан байхад дараа нь 2014 оны 8 сард БНХАУ уг гэрээг баталгаажуулсан байхад дараа нь 2014 оны 9 сард ОХУ баталгаажуулсан байна. ОХУ-тай байгуулсан гэрээ нь тунхаглалын буюу билэгдэлийн шинж чанарыг агуулж ОХУ манай талын байр суурийг харуулсан байдалтай, худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх сонирхол төдийлөн байхгүй, харин манай улсын эрдэс баялагийн түүхий эдийг (уран, нүүрс) олборлох, төмөр замын бүтээн байгуулалтанд оролцох сонирхол нь давамгайлж байна. Тэгвэл БНХАУ, Монгол Улсын бүх талын хамтын ажиллагаа улам эрчимжиж, энэ нь манай улсын эдийн засгийн аюулгүй байдалд ноцтой аюул учруулах хэмжээнд аль эрт хүрчээ гэж хэлж болно. Олон улсын жишигт аливаа улс бусад орноос 25 хувиас илүү гадаад худалдааны хамааралтай болох тохиолдолд автоматаар тухайн улсын эдийн засгийн аюулгүй байдал алдагдсан гэж үздэг. Тухайлбал, Монгол Улс 2013 оны байдлаар БНХАУ-ын зах зээлээс 86,8 хувийн экспортын, 28,7 хувийн импортын хамааралтай байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд дэлхийн улс орнуудын хооронд байгуулж буй стратегийн түншлэлийн гэрээний үзэл санаа, практик туршлагаас харахад геополитик, цэрэг, зэвсгийн зориулалтаар байгуулж байна. Манай улсын хувьд хоёр хөрштэйгээ байгуулсан стратегийн түншлэлийн гэрээ нь юуны түрүүнд улс орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах эрх ашигтай нийцэж байгаа эсэхэд нарийн шинжилгээ хийх шаардлагатай байна. Стратегийн түншлэл гэсэн халхавч дор манайх шиг жижиг улс том гүрэнд уусаж үгүй болох аюул эрсдэлийг тооцох нь чухал байна. Монгол Улс хоёр хөршийнхөө стратегийн ашиг сонирхолд автан өөрийн газар зүйн байршилтын стратегийн ач холбогдолыг дутуу үнэлж ОХУ болон БНХАУ-тай харилцах харилцаандаа давуу тал болгон бүрэн ашиглаж чадахгүй байна. Ийм нөхцөлд манай улсын хувьд гуравдагч хөрштэй стратегийн түншлэлийн гэрээг яаралтай байгуулснаар өөрийн стратегийн ашиг сонирхолоо хоёр хөрштэй ямар ч асуудал дээр сөргүүлэн тавьбал амжилт олох боломжтой гэж үзэж байна.

Иймд бид аливаа улстай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа цаашлаад стратегийн түншлэлийн гэрээг байгуулахдаа юуны өмнө манай улсад энэхүү гэрээг хийсний үр дүн, үр ашиг юунд байна, хэр ирээдүйтэй, бидний алс хэтийн стратегийн ашиг сонирхолд нийцэж байна уу, амьдрах чадвартай, хэрэгжих боломжтой гэдгийг шинжлэх ухааны үүднээс судалж төрийн эдийн засгийн гадаад бодлогоо боловсруулж хэрэгжүүлэхдээ хамтын ажиллагаа<=>үндэсний аюулгүй байдал; ардчилал<=>уламжлал; хүний эрх, эрх чөлөө<=> нийтийн эрх болон нийгмийн эрх ашиг гэх мэт үзүүлэлтүүдийн хоорондын зохистой харьцааг хангах буюу алтан дундажыг барьж байвал зүгээр байна.

НОМ ЗҮЙ

1. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын стратегийн түншлэлийн гэрээ. 2009 оны 08-р сарын 25 <http://vip76.mn/content/7969>
2. Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр, 2013 оны 10 дугаар сарын 25 <http://www.mongolianminingjournal.com/>
3. Стратегический менеджмент. Основы стратегического управления / М. А. Чернышев [и др.]. – Ростов н/Д : Феникс, 2009. – 506 с.
4. Стратегические направления устойчивого развития Байкальского региона (основные положения). – Иркутск: Изд-во БГУЭП, 2009. – 52с.
5. Суспицын С.А. Стратегия побуждения экономической активности в национальной экономике / С.А. Суспицын // Регион: экономика социология. – 2013.– №4.– С.37–60.
6. Стратегия социально-экономического развития Иркутской области на долгосрочную перспективу (до 2020 года). Центр стратегических разработок “Северо-Запад”. Иркутск. 2008. – Режим доступа: http://www.csr-nw.ru/upload/file_content_162.pdf
7. Томпсон А.А, Стрикленд А. Дж, «Стратегический менеджмент» Искусство разработки и реализации стратегии: Учебник / Пер с англ под ред Л.Г Зайцева, М.Соколовой - Банки и биржи, ЮНИТИ, 1988, - 576с

8. Стратегический менеджмент. Основы стратегического управления /М.А. Чернышев [и др.]. – Ростов н/Д: Феникс, 2009.- 506, [1] с.- (Высшее образование). С-11
9. <http://www.businessdictionary.com/definition/strategy.html>
10. <http://www.businessdictionary.com/definition/strategic-partner>
11. <http://azerros.ru/news/20254-ctrategicheskoe-partnerstvo>
12. <http://ru.journal-neo.org/2013/08/26/rus-strategicheskoe-partnerstvo>
13. english.cntv.cn ›
14. <http://www.mongolianminingjournal.com/>